



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 63

Мандалговь

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны А/33 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын 2021 оны II дугаар улирлын ажлын гүйцэтгэл, үр дүн, ажил гүйцэтгэх чадвар, арга барил, идэвх санаачилгыг үнэлэн 2021 оны III дугаар улирлын ур чадварын нэмэгдлийг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг хавсралтад заасны дагуу тооцож олгохыг газрын Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн, хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэн, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

57811901-5